


“Өнөөдөр: эх хэл бичиг” хэлэлцүүлэг

Манай клуб уламжлал хэлэлцүүлгийнхээ хүрээнд “Өнөөдөр: эх хэл бичиг” сэдэвт хэлэлцүүлгийг ШУТИС-ийн оюутан залуусын эх хэлний боловсрол, ирээдүйн ажлын байрны шаардлага, хэрэгцээг дэмжих зорилгоор зочин илтгэгчээр Монцамэ агентлагийн



ХҮМҮҮН БИЧИГ сонины эрхлэгч, монгол хэл бичиг судлаач-багш Б.Элбэгзаяаг урин өрнүүллээ.

Уригдсан зочин илтгэгч “Монголчуудын уламжлалт хэл бичиг түүх дурсгал, бидний сонгодог соёл-МОНГОЛ БИЧИГ түүнийг үзэж судлахын учир”, “2020 он монгол бичиг соёлд маань түүхэн эргэлт, сэргэлтийн эгзэгтэй үе ирсэн талаар”, “Бичиг соёл маань өнөөдөр, ойрх цагийн, ирж яваа цагийн чухам эзэн минь хэн юм бэ гэж та биднээс нухацтай асууж байгаа талаар” хэлэлцэн “Хүмүүн бичиг” анхны дугаар, өөрийн уран бүтээлийн цоморлигоо дурсгал болгон сониныхоо бодлого, агуулгыг танилцууллаа. Хэлэлцүүлэгт оролцсон хийгээд цахим шууд бичлэг /live/-аар хамрагдсан оюутнууд зочин илтгэгчээс монгол хэлний ижил дуудагддаг үг хэллэг монгол бичигт хэрхэн бичигдэх, журамласан толь бичгийн хэрэглээ, зөв бичих дүрэм, алтай язгуурын монгол хэл бичигт үгийн язгуур үндэс, дагавар нөхцлийн утга чухал болох, улс үндэстний хэлний давтагдашгүй онцлог, үгсийн сангийн дархлаа болох хэлц үг хэллэгийн талаар олон олон асуултаас хариултаа олсон өөр хоорондоо мэдээлэл мэдлэг солилцсон үр дүнтэй хэлэлцүүлэг боллоо.



30±оюутан live-аар 105 ± оюутан
2020.10.24

ШУТИС-ГХС

Ази судлалын тэнхим